



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.09.06 № 1-6/152
танай _____-ны № _____-т

ӨРГӨН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өргөн сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Өргөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Өргөн сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Өргөн сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Өргөн сумын сонгуулийн хороонд

Хавсралт...⁸...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Сумын МАН-ын хорооны бүх гишүүдийн хурлын
2020 оны ...06...-р сарын ...14...-ны өдрийн
...3... тоот тогтоолын хавсралт

ӨРГӨН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Өргөн сумын Монгол Ардын Намаас орон нутгийн ИТХ-ыг сонгох 2020 оны сонгуульд оролцохдоо Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох МАН-ын мөрийн хөтөлбөр, аймгийн ИТХ-д оролцох аймгийн МАН-ын мөрийн хөтөлбөр, тус сумын 2010-2021 оны "Хөгжлийн стратеги төлөвлөгөө"-г удирдлага болгон боловсрууллаа.

Сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн өсөлтийг түргэтгэн, хүн амын боловсрол, мэдлэг чадварыг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэн аятай тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, Төрийн албаны шуурхай хариуцлагатай байдлыг хангаж ажиллахад уг хөтөлбөрийн ЭРХЭМ ЗОРИЛГО оршино.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл иргэн

1.1.1 Суманд стандартын шаардлага хангасан 18 ортой эмнэлэг шинээр барих /Оношлогооны техник тоног төхөөрөмжөөр ханган ажиллана./

1.1.2 Орон нутгийн боловсон хүчин бэлтгэж тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажиллана.

1.1.3 Идэвхтэй эрүүл амьдрал хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутаг ханган ажиллана.

1.1.4 Эрүүл шүд эрүүл хүүхэд хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэн ажиллана.

1.1.5 Сумын Эрүүл мэндийн төвийг хөргүүртэй болгох



1.1.6 "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" "Эрүүл ирээдүй- Дорноговь" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

1.2 Боловсрол ,соёл урлаг биеийн тамирын чиглэлээр

Бодлогын зорилт – Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж улс, тив дэлхийн хэмжээнд хүрэх урлаг спортын авьяастнуудыг олноор төрүүлэн гаргаж олон нийтэд гоо зүй ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэх, Хүүхэд бүрт чанартай боловсрол олгох бүхий л нөхцөл боломжийг бүрдүүлж, оюунлаг, зөв хандлагатай, ахмад үе, үндэсний өв уламжлалаа дээдэлсэн иргэнийг бэлтгэх, багшлах боловсон хүчний хангамжийг бүрэн шийдвэрлэх

1.2.1 Суманд 320 хүүхдийн Ерөнхий боловсролын сургууль шинээр барих

1.2.2 Багш нарын чадавхийг сайжруулах зорилгоор сургалтанд хамруулах, гадаад улсын тэргүүн туршлага судлах нэвтрүүлэх ажил зохион байгуулна.

1.2.3 Шинээр барьж ашиглалтанд оруулсан 100 хүүхдийн цэцэрлэгийн дотор болон гадна орчныг тохижуулах ажлыг хийнэ.

1.2.4 Орон нутгийн боловсон хүчин бэлтгэж тогтвор суурьшилтай ажиллуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллана.

1.2.5 Унадаг дугуйн замыг шинээр тавьж , дугуйн спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.6 Биеийн тамир спортыг хөгжүүлэх чиглэлээр мөсөн гулгуурын болон хөл бөмбөгийн талбай байгуулна.

1.2.7 Сургалтын чанарыг ахиулах бүхий л нөөц боломжийг хэрэгжүүлж аймагтаа тэргүүлэх зорилт тавин ажиллана.

1.2.8 Соёл спортын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээний чанарт ахиц гаргана.

1.2.9 Түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах, соёлын биет бус өвийг бүртгэж олон нийтийн хүртээл болгох ажлыг бодит үр дүнд хүргэнэ.

1.2.10 Урлаг спортын салбарт өндөр амжилт гаргаж сум орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөж яваа иргэд, хүүхэд залуучуудыг алдаршуулах ажлыг тухай бүрд нь зохион байгуулж нийтэд сурталчилна.

1.2.11 Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг иргэдэд таниулах ажлыг зохион байгуулж ургийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлнэ.



1.3 Гэр бүл, хүүхэд хамгаалалын чиглэлээр

1.3.1 Гэр бүлийг дэмжих чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

1.3.2 Гурав хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагтаа ханган ажиллана.

1.3.3 Нийтийн эзэмшлийн талбай, Гэр хороололын байрнууд болон Ганзам, Найрамдал хорооны орон сууцнуудын дунд хүүхдийн тоглоомын талбай барина.

1.3.4 “Зорилтот бүлгийн өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

1.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.

1.3.6 Инженерийн шугам сүлжээнд холбогдсон ногоон байгууламж бүхий хямд өртөгтэй орон сууц барьж ашиглалтанд оруулна.

1.4 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

1.4.1 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, ААН-ийн дэргэд “Ахмадын сан” байгуулан ажиллах хуулийн хэрэгжилтийг орон нутагт ханган ажиллана.

1.4.2 Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого, “Ач санах” хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангуулна.

1.4.3 Суманд “Ахмадын өргөө” барьж ашиглалтанд оруулна.



ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Дэд бүтэц, үйлдвэрлэлийг сайжруулах бодлого:

Бодлогын зорилт – Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бүтээн байгуулалт, дэд бүтцийг сайжруулан жижиг, дунд болон томоохон үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана.

2.1.1 Улс , аймаг, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татварын далд эдийн засгийг ил болгох зохицуулалтын арга хэрэгслийг ашиглан орон нутгийн орлого бүрдүүлэх боломжит бүхий л эх үүсвэрийг дайчлан ажиллана.

2.1.2 Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэн байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий боловсруулах үйлдвэрийг дэмжинэ.

2.1.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах хөрөнгө оруулалтыг сурталчлан бүтээн байгуулалт , тохижилт, бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.4 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулахад иргэд олон нийтийн оролцоог хангана.

2.1.5 Сайншанд суманд “Өргөн үйлдвэрлэв” нэрийн барааны дэлгүүр нээн ажиллуулна.

2.1.6 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай томоохон үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөрийг бодлогоор дэмжин ажиллах хүчийг орон нутгаас бүрдүүлэн хамтран ажиллах гэрээний дагуу ажлын байрыг нэмэгдүүлэн ажилгүйдлын тоог бууруулан ажиллана.

2.2 Байгаль орчин , аялал жуулчлалын чиглэлээр

2.2.1 Хамарын хийд , Аргалын уул орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд оруулах талаар шаардагдах судалгаа шинжилгээний ажлыг хийн холбогдох байгууллагад уламжлан ажиллана.

2.2.2 Хамарын хийд, Өргөн сум, Аргалын уул гэсэн маршрутыг бий болгож аялал жуулчлалын чиглэлээр ажиллах Аж ахуй нэгж , байгууллага , иргэдийн санал санаачлагыг төрийн бодлогоор дэмжин ажиллана.



2.2.3 Аялал жуулчлалын чиглэлээр ажиллах хувь хүн ААН-ын санаачлагыг төрийн бодлогоор дэмжин ажиллана.

2.2.4 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг шат дараатай нэмэгдүүлнэ

2.2.5 Сумын хог хаягдлын нэгдсэн цэгийг булшилж шинээр тохиромжтой газарт байршуулж хог хаягдлын менежментийг сайжруулан хог хаягдлыг ангилан ялгаж хаях цэгийн тоог нэмэгдүүлэх, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар иргэдэд сургалт сурталчилгааг хийж хэвшүүлнэ.

2.2.6 Гэр хорооллын гудамжны тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор “Жишиг хашаа” хөтөлбөрийг боловсруулж иргэдийн оролцоотой шат дараатай хэрэгжүүлнэ

2.2.7 “Нэг иргэн нэг мод” аян өрнүүлж өрх бүрийг өрхийн гишүүний тоогоор мод тарих хөдөлгөөнийг жил бүр өрнүүлж ажиллана

ГУРАВ : ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1 Төрийн үйлчилгээний бодлого

Бодлогын зорилт – Төрийн үйлчилгээг иргэдийн оролцоонд тулгуурласан, ил тод, нээлттэй, хуулийг дээдэлсэн, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, төрийн албыг төлөвшүүлэх.

3.1.1 Төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх мэргэшүүлэх талаар онцгой анхаарч дотоодын болон бусад сургалт, хөтөлбөрт тогтмол хамруулах

3.1.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин төрийн албыг иргэдэд хөнгөн шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй хүргэж хэвшинэ

3.1.3 Төсвийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, ажлын цаг ашиглалтыг сайжруулан төрийн албаны стандартыг ханган ажиллаж харилцан туршлага мэдээлэл солилцон иргэдийг үнэн бодитой нэгдсэн мэдээ мэдээлэлээр хангах ажлыг шинэ шатанд гаргана



3.1.4 Хүнд сурталгүй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж , төрийн албан хаагчдыг чадавхжуулан ажиллана.

3.1.5 Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас батласан аргачлалыг мөрдөн иргэд , олон нийт, төрийн албан хаагчдын дунд авлигаас урьдчилан сэргийлэх соён гийгүүлэх арга хэмжээ тогтмол зохион байгуулна.

3.1.6 Орон нутгийн язгуур эрх ашгийн төлөө тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагууд ТББ-уудын ажлыг дэмжиж хамтран ажиллана.

3.2 Аюулгүй байдал, гамшгаас хамгаалах бодлого

Бодлогын зорилт – Иргэдийн амгалан тайван байдлыг хангах, аятай тухтай амьдрах эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, салбар зөвлөлүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах

3.2.1 Сумын Цагдаагийн тасаг, ГХУСАЗСЗ, Хүүхэд хамгаалалын хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөл, Эцэг эхийн зөвлөлийн хоорондын уялдаа холбоог сайжруулан мэдээ мэдээллийг шуурхай солилцож хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт зэрэг гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллана

3.2.2 Суманд үйл ажиллагаа явуулдаг АА бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж нөлөөллийн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ

3.2.3 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Малчдын бүлэг байгуулах ажлыг багийн Засаг дарга, БИНХ-ын Тэргүүлэгчидтэй хамтран зохион байгуулж бүлгүүдийн ажиллах чиглэл гаргаж урамшууллын системийг боловсруулан идэвхжүүлж ажиллана

3.2.4 Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээ, самбар байршуулах, жолооч, зорчигчдод урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл хүргэх, ажлыг тогтмол зохион байгуулж осол гэмтлийн тоог бууруулах



ДӨРӨВ : НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1 Хөдөө аж ахуйн чиглэлээр

4.1.1 Бэлчээрийн төлөв байдал чанарт дүн шинжилгээ хийж , бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан цөлжилтөөс сэргийлэх , бэлчээрийн талхдалтыг бууруулж уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.

4.1.2 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн ААНэгж, байгууллагын санаачлагыг дэмжин “Монгол мал” хөтөлбөрийг сумандаа үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

4.1.3 Малын түүхий эд, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барих

4.1.4 Малчид нэгдэн хорших үйл ажиллагааг дэмжин, жижиг дунд үйлдвэрлэл, нөхөрлөл хоршоо байгуулан ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.1.5 Бэлчээрийг зөв зохистой ашиглах байгаль орчныг хамгаалах, малчдын хөдөлмөрийг хорших зорилгоор байгуулагдсан Сумын Бэлчээр ашиглагчдын холбооны бодлого шийдвэрийг дэмжин хамтран ажиллана.

4.1.6 Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мал нядалгааны стандартын төвлөрсөн цэг барих

4.2 Хариуцлагатай уул уурхай

4.2.1 Газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор, сумын хил хязгаарын цэсийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулж , сумын хилийн цэсийн захын цэгүүдэд багана босгож, ААН ба ТББ-уудын хүч хөрөнгөөр шийдвэрлэнэ.

4.2.2 Орон нутагт байгаль орчныг хамгаалах , нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх ТББ-ын үйл ажиллагааг бүх талаар дэмжин хамтран ажиллана.

4.2.3 Агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүн олборлож буй болон ачиж буулгах газарт тоосонцроос хамгаалах тусгай байр техник тоног төхөөрөмж байгуулах, ашиглахад хяналт тавин ажиллана.

4.2.4 Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээхгүй , байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа ААН-ийн тусгай зөвшөөрлийг цуцлах тухай санал боловсруулах эрх бүхий албан тушаалтанд уламжлах бодлого баримтлан ажиллана.



ТАВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Нутгийн хөгжил бүтээн байгуулалт

5.1.1 “Улсын тэргүүний сум” болох зорилт тавина ажиллана.

5.1.2 Өргөн сумын төв инженерийн шугам сүлжээг шинэчлэн өргөтгөх, төмөр замын байр болон гэр хорооллыг цэвэр бохир ус, дулааны шугамд холбох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

5.1.3 Суманд цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

5.1.4 Сумын суурьшлын дэд бүсэд дэд бүтэц барина.

5.1.5 Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сум доторхи авто зам тавих асуудлыг шийдвэрлэнэ.

5.1.6 Сумын төвийн гэрэлтүүлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.1.7 Сумын төвийг камержуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.1.8 Их говийн зоригтны хүүхэд залуучуудын талбайн тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.

5.1.9 Сумын төвийн нийтийн орон сууцнуудын дээвэр засварлах ажлыг бүрэн хийж дуусгана.

5.1.10 Хөдөөгийн багийн төвүүдийг шинээр барих, засварлах, тохижилтын ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ.

5.1.11 Сумын төв Эко –ОО-ийг бий болгоно.

ӨРГӨН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.04.06 № 1-6/633
танай _____-ны № _____-т

**САЙХАНДУЛААН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сайхандулаан сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сайхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Сайхандулаан сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхандулаан сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Сайхандулаан сумын сонгуулийн хороонд

Хавсралт...⁴...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
САЙХАНДУЛААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Уриалга: Орон нутгийхаа хөгжлийн төлөө
Олуулаа хамтдаа зүтгэе.**

Аймгийн МАН-ын Бага хурлаас дэвшүүлсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ирэх дөрвөн жилд ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилтыг агуулсан мөрийн хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү мөрийн хөтөлбөрөөр сумын МАН-ын хороо хөдөлмөрийн насны хүн бүрийг ажилтай орлоготой болгон өрх бүрийн орлогыг нэмэгдүүлэн ажилгүйдлийг багасгаж, ядуурлыг бууруулж ажиллана гэж үзэж байна. Мөрийн хөтөлбөрийг гадаад дотоодын хөрөнгө оруулалт, улсын төсөв орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр тооцоо судалгаанд үндэслэгдсэн тул хэрэгжих бүрэн боломжтой юм.

Сумын МАН-ын хороо 4 бүлэг, 48 заалтаас бүрдсэн мөрийн хөтөлбөрийг сонгогч Танд толилуулж байна.

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

- 1.1.1. Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг дэмжиж ажил эрхлэлтийн түвшинг дээшлүүлнэ.
- 1.1.2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг төрийн бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.1.3. Ажлын байр нэмэгдүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих
- 1.1.4. Аймаг, орон нутгийн хэмжээнд ажилгүйдлийг бууруулах иргэдийг ажлын байраар хангах сумын бодлого хэрэгжүүлэх
- 1.1.5. Өрх бүр үйлдвэрлэгч хөдөлгөөн өрнүүлж бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн болон эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх
- 1.1.6. Ажилгүй иргэдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх ажлын байраар хангах цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- 1.1.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд оруулсан аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.
- 1.1.8. Залуу гэр бүл, амьдралын баталгаажих төвшнөөс доогуур орлоготой айлын хүүхдийн аж байдлын судалгааг жил бүр хийж, түүний мөрөөр тодорхой ажил зохиож, үр дүнг тооцно.
- 1.1.9. Сум, орон нутгаа хөгжүүлэх дэвшилтэт санал, санаачилга гарган төсөл, хөтөлбөр боловсруулсан залуучууд, баг хамт олныг төрийн бодлогоор дэмжинэ
- 1.1.10. Сумын төвийг ЭКО-00-той болгох



1.2 Боловсрол,эрүүл мэнд,соёлын бодлого

- 1.2.1. Боловсролын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 1.2.2. Залуучуудын насан туршийн боловсролын хэрэгцээнд тохирсон хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 1.2.3. Хүүхдийн сэтэхүйг хөгжүүлэх, монгол ёс заншлаа эзэмшүүлэх сургалтыг ахмадуудын хүчээр зохион байгуулах ахмадын өргөөнд танхимтай болох
- 1.2.4. Эрүүл мэндийн төвийн өргөтгөл хийж эхийн амрах байр барина.
- 1.2.5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд их засвар оруулах
- 1.2.6. СӨБ-ын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж багш хөгжлийн төвийг бий болгож тохижуулах, хөгжмийн заалыг цахилгаан тоног төхөөрөмжөөр хангах
- 1.2.7. Соёлын төвийг шинээр барина
- 1.2.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гаднах орчинг тохижуулах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх.
- 1.2.9. Хүүхэд залуучуудын амьдрах ухааны хүртээмжийг нэмэгдүүлэх
- 1.2.10. Сургууль, Соёлын төвийн секц дугуйлангуудын тоог нэмэгдүүлж сурагчдад мэргэжлийн баримжаа олгох бодлого барина.
- 1.2.11. Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах чиглэлээр ажлуудыг зохион байгуулах
- 1.2.12. Иргэдэд мэргэжлийн урлагийн шилдэг бүтээл, соёл, урлагийн чанартай үйлчилгээг хүргэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана
- 1.2.13. Хүн эмнэлгийн түргэн тусламжийн хүртээмжийн чанарыг сайжруулахад анхааран түргэн тусламжийн машинтай болох, хүнд өвчтнийг хянах монитер багажтай болгоход дэмжлэг үзүүлэх

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1.1. Гэр хорооллын хашаа, эгнээ байршлыг цэгцэлж тохижуулан өнгө үзэмжийг сайжруулах
- 2.1.2. Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг талбайн хэмжээг багасгаж эмх цэгцтэй болгох
- 2.1.3. Иргэдийн амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор хоггүй орчинг бүрдүүлж био ОО-той болгох
- 2.1.4. Төвийн гудамж гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
- 2.1.5 Залуу хоршоологчид хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрт санал оруулах. /Иргэний нийгмийн байгууллагын оролцоотой/
- 2.1.6. Мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулна



- 2.1.7. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг бодитой хийж, бэлчээрийг зохистой ашиглахаар бэлчээрийн менежмент төсөл хэрэгжүүлэх
- 2.1.8. Сумын төвд ундны усны худаг гаргаж, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулан, ухаалаг системд шилжүүлэх
- 2.1.9. Малчдад төрөөс үзүүлэх эмнэлэг, боловсрол, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна
- 2.1.10. Малчдын худаг усны асуудалд анхаарч, отрын бэлчээрийг усжуулах, гаргасан худгийг лайдах сэргээн засварлах
- 2.1.11. Газар тариалан эрхлэгчдэд төрөөс дэмжлэг үзүүлэх
- 2.1.12. Хүлэмжийн аж ахуйг урамшуулан дэмжиж иргэдийг нарийн ногоогоор хангах
- 2.1.13. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг урамшуулан дэмжиж нийлүүлэлтийг нэмэгдүүлэх
- 2.1.14. Багуудын малчдын бэлчээр, усны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж отрын бэлчээрт гүний худаг гаргах
- 2.1.15. Сумын ахуйн үйлчилгээний төвд өргөтгөл хийж халуун ус, үсчиний ажлын байр нэмэгдүүлэх
- 2.1.16. Сумын төвийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг гүйцээж, сумандаа сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

- 3.1.1. Хүүхдийг багаас нь байгаль эх дэлхийдээ хайртай болгох зорилгоор "1 хүүхэд-1 мод" төслийг хэрэгжүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- 3.1.2. Суманд уул уурхайн лицензийн зөвшөөрлийг багасгах, газрын нөхөн сэргэлтийг хийх
- 3.1.3. Байгальд ээлтэй бизнесийн орчин бүрдүүлэх
- 3.1.4. Мод тарих ажлыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

- 4.1.1. Төрийн байгууллагуудын салбар хоорондын уяалдаа холбоог сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалтын нэгдсэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг шинэчилнэ.
- 4.1.2. Төрийн албан хаагчдын ёс суртахуун, мэндлэх ёсыг эзэмшүүлэх, харьцааны соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, хариуцлага тооцож ажиллах
- 4.1.3. Иргэдийн оролцоонд тулгуурласан Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхижуулна.
- 4.1.4. Иргэдийн эрх, эрх чөлөө, хариуцлага, хууль дээдлэх зарчимыг удирдлага болгон төрийн албаны хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.1.5. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Иргэд төрийн үйлчилгээг нэг дороос, авах ая тухтай боломжийг бүрдүүлж ажиллана.



4.1.6 Гэмт хэрэг, малын хулгай, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бодлогыг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлж, дэмжиж ажиллана.

4.1.7 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

4.1.8 Суурин газруудын болон уул уурхайн эдэлбэр газруудад байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн оролцоо, хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.9 Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах төрийн бодлого, зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.

САЙХАНДУЛААН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

2020.05.31

Сайхандулаан сум





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 16/34
танай _____-ны № _____-т

**УЛААНБАДРАХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбадрах сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Улаанбадрах сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Улаанбадрах сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Улаанбадрах сумын сонгуулийн хороонд

Хавсралт...⁵...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

**УЛААНБАДРАХ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020-2024 ОНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ: НИЙГМИЙН БОДЛОГО

1.1. АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛНА:

- 1.1.1. Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг дэмжиж, ажил эрхлэлтийн түвшинг тогтмол ахиулна.
- 1.1.2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг төрийн бодлогын хүрээнд дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.1.3. “Малжуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх замаар ажилгүйдлийг бууруулж, малчдын амьдралын нөхцлийг сайжруулна.
- 1.1.4. Аймгийн хэмжээнд ашиглалтанд орох үйлдвэрүүдэд шаардлагатай ажилчидыг МСҮТ-өөр дамжуулан богино хугацааны сургалтанд хамруулж бэлтгэнэ.
- 1.1.5. Суманд шаардлагатай мэргэжилтэнүүдийг бэлтгэхэд боломжит бүхийл хэлбэрийн дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.6. Их дээд сургууль төгсөгчид, цэргийн албанаас халагдаж ирсэн иргэдийг эхний ээлжинд ажлын байраар хангах бодлого барьж ажиллана.

1.2. ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР:

- 1.2.1. Аймгаас боловсруулан батлах “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийн орон нутагт ханган ханган ажиллана.
- 1.2.2. Хүүхэд хөгжлийн төвийг шинээр байгуулж, гэр бүлийн талаарх болон бусад сургалт мэдээ, мэдээллийг хүргэн ажиллана.
- 1.2.3. Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой залуу гэр бүлийг дэмжих ажлыг зохион байгуулна.
- 1.2.4. Жирэмсэний хяналтыг сайжруулан, эрт илрүүлэлтийг стандартын түвшинд хүргэж ажиллана.

1.3. АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТАЛААР:

- 1.3.1. Ахмадуудын дунд жил бүр тэмцээн уралдаан зохион байгуулж, боломжит бүхий л хэлбэрээр дэмжин ажиллана.
- 1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад тусалж дэмжинэ.
- 1.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гадаад дотоодын их дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ



1.1.ЭРҮҮЛ МЭНД АМЬДРАЛЫН БАТАЛГАА

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дадал, хандлагатай болгож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.

1.4.1. Эмч, ЭМТ-ийн ажилтануудын ур чадварыг дээшлүүлэхээр өндөр хөгжилтэй улс орон, дотоод гадаадын урт богино хугацааны сургалтуудад хамруулж, сайн туршлагыг нэвтрүүлнэ.

1.4.2. Эмнэлгийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж үйлчилгээний чанарыг сайжруулна

1.4.3. Эрүүл мэндийн анхан шатны эрт илрүүлгийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.4.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчлүүлэгчидэд ээлтэй эрүүл мэндийн дэмжлэгт орчинг бүрдүүлнэ.

1.4.5. “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн, хүний дархлал хомсдолын вирус, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.6. “Эмийн талаар баритлах бодлого”-ийг хэрэгжүүлж, эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

1.4.7. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж, урьдчилан сэргийлэх олон талт ажлыг зохион байгуулна.

1.4.8. “Эрүүл шүд” аяныг өрнүүлж “явуулын амбулатори” шүдний үзлэгийг тогтмолжуулна.

1.4.9. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ахмадуудад хүргэх ажлыг тогтмолжуулж, чанарыг дээшлүүлнэ.

1.4.10. Эрүүл мэндийн төвд цогцос хадгадах байр шинээр барина.

1.5. БОЛОВСРОЛ, СОЁЛ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

Боловсрол, соёл урлагийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, чанар үр ашгийг тасралтгүй дээшлүүлж, боловсон хүчний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн орчин нөхцлийг сайжруулна.

1.5.1. Багш ажилчидын хөдөлмөрийн таатай орчинг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгөөр бүрэн хангана.

1.5.2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч боловсрох орчин нөхцлийг сайжруулан, сургалтын чанарыг ахиулан ажиллана.

1.5.3. Улс болон орон нутгийн чанартай сургалтад багш нарыг үе шаттай хамруулж, боловсролын болон мэргэжлийн зэргийг ахиулна.

1.5.4. Хичээлээс гадуур спортын төвийг түшиглэн секц дугуйлангууд хичээллүүлж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлнэ.

1.5.5. Эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтыг сайжруулж, Монгол бичгийг сэргээн дэлгэрүүлж, сургаж өвлүүлэх, монгол бичгийн заах арга зүй, цахим хэрэглээг төлөвшүүлнэ.

1.5.6. “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган, тавих хяналтыг сайжруулна.



1.5.7. Хагас болон бүтэн өнчин хүүхдийг боловсрол эзэмших нөхцлөөр хангаж, дэмжиж ажиллана.

1.5.8. Насанд хүрэгчдийн дунд олон төрлийн секц дугуйлан хичээллүүлэн, олон төрлийн тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулна.

1.5.9. “Бага олимп” спортын наадмыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

1.5.10. Бүсийн чанартай соёл урлаг, спортын уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.

1.5.11. Номын сангийн ашиглалт, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын биет болон биет бус өвийг хадгалах хамгаалах ажлыг эрчимжүүлж соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулна.

1.5.12. Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалах ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан нэмэгдүүлж, Аймаг, сумын хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлнэ.

1.5.13. Спортын олон төрлийг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана.

1.5.14. Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлж, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулахыг дэмжиж ажиллана.

1.5.15. Аймгийн болон түүнээс дээш чанартай спортын төрөлд өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч нарыг урамшуулан ажиллана.

ХОЁР: БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Хөдөө аж ахуйд онцлон анхаарч мал сүргээ өсгөн эрүүлжүүлж, таваарлаг чанарыг нь сайжруулан эрүүл малтай сум болж, бүтээн байгуулалт өрнүүлэн дэд бүтцэд ахиц гарган иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд эдийн засгийн бодлого чиглэгдэнэ.

2.1.1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, монгол малчин, монгол мал хөтөлбөрийг орон нутагт үр нөлөөтэй хэрэгжүүлнэ.

2.1.2. Малын үүлдэр угсааг сайжруулан эрүүлжүүлж эрүүл малтай сум болно.

2.1.3. Сумын төвийн хувийн орон сууцнуудыг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбоно.

2.1.4. Сумын төвийг аймагтай хатуу хучилттай авто замаар холбох ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, эхлүүлнэ.

2.1.5. Сумын төвийн орон сууцны тоог нэмэгдүүлнэ.

2.1.6. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна.

2.1.7. Малчдад жуулчлах малчдын хоршоо байгуулах санал санаачлагыг дэмжинэ.

2.1.8. Сумын төвийн гэр хорооллын жишиг гудамж төсөл хэрэгжүүлнэ.

2.1.9. Сумын төвийн 15/04 агаарын шугамын дэд станцыг нэмэгдүүлж, урсгал засвар, өргөтгөл хийнэ.

ГУРАВ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялагийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, үр шимийг нь урт хугацаанд нь хүртэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгож, орчны тогтвортой хөгжлийг хангана.

3.1. Байгаль орчны чиглэлээр:

3.1.1. Хүн амын ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж тавих ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээг 40 хувьд хүргэнэ.



3.1.3. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулж, газар нутгийг нөхөн сэргээнэ.

3.1.4. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг үзүүлэхгүй байхаар зохион байгуулна.

3.1.5. Сумын төвийн 3 байршилд “ус түгээх-ухаалаг байр” байгуулна.

3.2. Ногоон хөгжлийн чиглэлээр:

3.2.1. Сумын заган ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд ТББ-ын оролцоог нэмэгдүүлж, сум, суурин газарт ногоон байгууламжийг ихээр байгуулсан иргэн ААН-ийг урамшуулна.

3.2.2. Иргэдийн өмчлөлийн газар дах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2.3. Ховор болон ашигт ургамлыг үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарьж ургуулах санал санаачлагыг дэмжин ажиллана.

3.3. Аялал жуулчлалын чиглэлээр:

3.3.1. Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжинэ.

3.3.2. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг барих хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. ТОГТВОРТОЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

4.1.1. Төрийн албаны сул орон тоог нээлттэй мэдээлж, төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулалтанд оролцох боломжийг хангана.

4.1.2. Сумын ИТХ, Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааны уялдааг ханган, олон нийтэд ил тод нээлттэй ажиллана.

4.1.3. Сумын Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд үнэн бодитоор шуурхай хүргэнэ.

4.1.5. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, сургах сургалтын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн, хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

4.1.6. Төрийн албан харилцаанд үндэсний бичгийг хослуулан хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангана.

4.1.7. Төрийн албан хаагчдыг ажил мэргэжлийн чиглэлээр нь дотоодын их дээд сургуулиудад суралцахыг дэмжинэ.


4.1.8. Албан хаагчдыг мэдлэг боловсрол, туршлага чадварыг нь харгалзан томилох, дэвшүүлэх зарчмыг баримталж, жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангана.

4.1.9. Багийн Засаг дарга нарын албаны унааг ээлж дараалалтайгаар шинэчилнэ.

4.1.10. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн албан хаагчдыг иргэдээр үнэлүүлэх, үнэлгээнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.11. Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй тайлагнах ажлыг зохион байгуулахад иргэдийн оролцоог хангана.

4.1.12. Нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргахад тухайн орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагуудын саналыг тусгана.



- 4.1.13. Эрх бүхий албан тушаалтнаас гарч буй шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.14. Архинд донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, архинаас гарах иргэдийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан “АА” бүлгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.1.15. Олон нийтийн дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон төрөлт арга хэмжээг зохиолн байгуулж, шуурхай байдлыг хангаж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.
- 4.1.16. “Нэг баг-Нэг агт” хөдөлгөөн өрнүүлж, хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.17. Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.
- 4.1.18. Малын хулгайтай тэмцэх чиглэлээр багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг чиглүүлж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, үр дүнг дээшлүүлнэ.

4.2. ЦЭРЭГ, ГАМШГААС ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.2.1. Сумын хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл бэлэн байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Олон нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 4.2.3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах нэгдсэн дадлага сургуулийг зохион байгуулж, техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулна.
- 4.2.4. Сумын хэмжээнд өвс, тэжээлийн нөөц бэлтгэх санг бэхжүүлж, нэмэгдүүлнэ.
- 4.2.5. Батлан хамгаалах багц хуулиудыг сурталчлах сургалт сурталчилгаа, уралдаан тэмцээнийг олон нийтийн дунд зохион байгуулна.
- 4.2.6. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл үүрэгтэн, дүйцүүлэх албаны бүрэлдэхүүний сургалтад бэлтгэл үүрэгтнүүдийг хамруулна.
- 4.2.7. Дайчилгааны нөөцийн бэлтгэл офицер I, II зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг Аймгийн цэргийн хэлтэстэй хамтран зохион байгуулна.
- 4.2.8. Зэвсэгт хүчний болон хил хамгаалах салбарын үйл ажиллагаанд орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.1. Орон нутгийн аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийг хамгаалах бодлогыг баримтлан олон улс, бүс нутгийн банк, төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, хөнгөлөлттэй зээл, тусламж дэмжлэг авах нөхцөл бүрдүүлэн бүтээн байгуулалтын төслүүдийг үр дүнтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 4.3.2. Хөрш улс орон, муж, тосгоны залуучуудыг суралцах, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, туршлага судлуулах, чуулган зөвлөгөөнд оролцуулахыг дэмжинэ.

УЛААНБАДРАХ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 16/016
танай _____-ны № _____-т

**ХАТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хатанбулаг сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Хатанбулаг сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хатанбулаг сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Хатанбулаг сумын сонгуулийн хороонд

Хавсралт...4....хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Монгол Ардын Намын Хорооны Бүх гишүүдийн
Хурлын 2016 оны 25 сарын 18-ны өдрийн 27-р
тогтоолын хавсралт

**ХАТАНБУЛАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
2020-2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хатанбулаг сумын Монгол Ардын Намын Хороо орон нутгийн хурлын 2016 оны сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж 2020 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө иргэдийн санал, хүсэлтэд үндэслэн, өрх бүрийн бодит орлогыг нэмэгдүүлэх, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулалаа. Мөрийн хөтөлбөрийг гадаад дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, төсөв санхүүгийн зөв бодлогоор хангаж, бүтээн байгуулалт өрнүүлэн урьдын адил бүрэн хэрэгжүүлсэнээр сумын нийгэм эдийн засгийн хөгжил, ард иргэдийн амьдралд ахиц, өөрчлөлт гарна гэж үзэж байна. Сумын Монгол Ардын Намын Хороо орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг сонгогч таньд толилуулж байна.

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 1.1. Ажлын байр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.2. Сумын хэмжээний ажилгүйдлийг үе шаттай бууруулж хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ.
- 1.3. Мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг малжсауулах төсөлд тэргүүн ээлжинд хамруулна.
- 1.4. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Уул уурхайн компани, аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлнэ.
- 1.5. Сумын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж нэн ядуу, амьжиргааны түвшин доогуур өрхөд чиглэсэн нийгмийн хамалжийн цогц бодлого арга хэмжээг төр засгийн бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлнэ.
- 1.6. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хувийн хэвшлийн хөрөнгөөр суманд болон аймагт баригдах нийтийн орон сууцанд хамрагдах боломжоор хангана.
- 1.7. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Орлоготой залуу" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.8. Залуу гэр бүлийг хувийн хэвшлийн хөрөнгөөр суманд баригдах нийтийн орон сууцанд хамрагдах бодлого баримтлан ажиллана.
- 1.9. Ахмад настнуудыг жилд нэг удаа эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонд хамруулна.
- 1.10. Ахмад настнуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдах нийтийн орон сууцанд хамрагдах бодлого баримтлан ажиллана.
- 1.11. Ахмадын хуучин өргөөг их засварт оруулан ашиглалтыг сайжруулна.
- 1.12. Эрүүл мэндийн төвийг шинэчлэн өргөтгөл хийнэ.
- 1.13. Цахим эрүүл мэнд төслийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.14. Эрүүл мэндийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд иргэдийн оролцоог ханган чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

44171/2023
БҮЯА 0056 9025707

- 1.15.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг иргэдэд ойртуулан чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.16."Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж элэгний В, С вирусын голомтыг бүрэн устгах ажлыг ойрын жилүүдэд дуусгана.
- 1.17.Суманд гэр цэцэрлэг, хүүхэд асрах төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 1.18.Хүүхдийн Цэцэрлэгийн барилгад их засвар хийх.
- 1.19.Цэцэрлэгийн хүүхдийн зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжийг сайжруулах.
- 1.20.Ерөнхий боловсролын сургуулийн болон Цэцэрлэгийн багш нарын мэргэжил, боловсролыг дээшлүүлж давтан сургалтанд хамруулах мэргэшүүлэх.
- 1.21.Сумын Ерөнхий Боловсролын Бага сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг хийх. /560 хүүхэд/
- 1.22.Багш нарын 8 айлын орон сууцыг шинэчлэх.
- 1.23.ЕБСургуулийн спорт зааланд урсгал засвар хийх, тоног төхөөрөмжөөр хангах.
- 1.24.Соёлын төвийн ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангах.
- 1.25.Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.
- 1.26.Биеийн тамир, спортын тоноглол бүхий талбайг байгуулна.
- 1.27.Сумын Соёлын төв, Спорт цогцолборыг материаллаг баазаар хангах.
- 1.28.Иргэдийн хөгжлийн төвийн дотор тохижилт тоног төхөөрөмжөөр хангах.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1.Хатанбулаг Ханги чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж Ханги суурьшлийн бүсийг байнгын эрчим хүчээр хангахад орон нутгаас идэвхитэй оролцоно.
- 2.2.Сумын төвийг хатуу хучилттай авто замаар, Ханги, Мандал, Зүүнбаян чиглэлийн төмөр замтай холбох ТЭЗҮ боловсруулан эхлүүлнэ.
- 2.3.Сумын төвд шилэн кабель тавьж өндөр хурдны интернэт, мэдээлэл холбооны үйлчилгээг нэвтрүүлэн, интернет үйлчилгээний тусгай цэгтэй болгох.
- 2.4.Ундны усны стандарт шаардлага хангаагүй зарим цэгт цэвэршүүлэх төхөөрөмж тавьж ухаалаг худгийн системийг бүх худгуудад нэвтрүүлнэ.
- 2.5.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон нутагт нэн шаардлагатай төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болох.
- 2.6.Сумын төвийн шинэ суурьшлийн бүсэд дэд бүтцийг сайжруулах.
- 2.7.Сумын төв болон Ханги суурьшлийн бүсийн гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, хуучин нарны сэргээгдэх эрчим хүчээр асдаг гэрэлтүүлэгүүдийг бүрэн засварлаж ашиглалтад оруулна.
- 2.8.Сумын төвийн ундны усны цэгийг нэмэгдүүлэх болон шинэ суурьшлийн бүсэд гүний худаг шинээр гаргана.
- 2.9.Сумын төвийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хогийн цэгийг цэгцэлж стандартын шаардлагад нийцүүлж ажиллана.
- 2.10.Төвлөрсөн цэвэр, бохир, дулааны шугамыг иргэдийн өмчийн газарт ойртуулан үе шаттай нэмэгдүүлнэ.



- 2.11.Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол бүхий төвлөрсөн орон сууц барина.
- 2.12.Ханги хилийн боомтод төвлөрсөн уурын зуух барьж нэгдсэн халаалт цэвэр, бохир усны шугамд тавина.
- 2.13.Төрөөс малчдын талаар баримтлах бодлого "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж малын үүлдэр угсааг сайжруулан тоонд бус чанарт анхаарч шилмэл цөм сүрэгтэй болох.
- 2.14.Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг бодитой хийж бэлчээрийг зохистой ашиглахаар бэлчээрийн менежмент төслийг хэрэгжүүлнэ.
- 2.15."Ус чандмань эрдэнэ" хөтөлбөр боловсруулан усны ойрын 10 жилийн бодлогыг тодорхойлж, малчдын ундны болон бэлчээрийн усны хангамжийг үе шаттай нэмэгдүүлж цэнгэг усыг бохирдуулахгүй хамгаална.
- 2.16.Сумын Мал эмнэлэг үржлийн алба болон мал эмнэлэгийн тасгийн албыг бэхжүүлж, боловсон хүчнийг сургаж, ажиллах тоног төхөөрөмжийг шийдвэрлэнэ.
- 2.17.Цахилгааны шөнийн тарифын асуудлыг суманд бүрэн шийдвэрлэх.
- 2.18.Суманд малын тэжээл бэлтгэх цех байгуулна.
- 2.19.Аж ахуйн нэгж, өрхөд гахай, тахиа, шувуу, үржүүлэх нөхцлийг бүрдүүлж үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.20.Хөдөөд гүний худаг шинээр гаргана.
- 2.21.Сумын нутаг дэвсгэрт зэрлэг ан амьтан услах зорилгоор "Хөв цөөрөм" байгуулна.
- 2.22.Хөдөөгийн багуудад цахилгаан халаалтыг шийдвэрлэх.
- 2.23.Хөдөөгийн багуудад үүрэн телефоны сүлжээг нэвтрүүлэх.
- 2.25.Сумын Засаг Даргын Тамгын Газрын өргөтгөлийг хийнэ.

ГУРАВ. БАЙГАЛЬД ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 3.1.Улсын болон аймаг сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг хэмэгдүүлж ховор болон ховордож буй ан амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулж улс, аймаг, сумын тусгай хамгаалалтад авна.
- 3.2.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
- 3.3.Сумын хэмжээнд мод бут зүлэг тарих хөдөлгөөнийг өрнүүлж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 3.4.Ханги хилийн боомтыг түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.5.Хөрш болон хамтын ажиллагаатай улс орон, тэдгээрийн муж хотуудтай гэрээ, хэлэлцээр байгуулж үр өгөөжийг нь сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхүү ашиглах бодлого барьж ажиллана.Багш, эмч сурагч солилцоог сайн туршлагад сургах, монгол уламжлал, ХАА, соёл урлагийн чиглэлээр хамтарсан томоохон уралдаан тэмцээнийг зохион байгуулах.
- 3.6.Орон нутгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гадаад харилцааг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг хангахад анхаарна.

ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

- 4.1.Иргэдийнхээ оролцоонд суурилсан төрийн албыг бий болгоно.



- 4.2.Цахим төрийн албыг хэрэгжүүлнэ.
- 4.3.Авлига, ашиг сонирхлын зерчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлнэ.
- 4.4.Орон нутагт зохион байгуулагдаж буй төсөл хөтөлбөр, тендер шалгаруулалтыг цахимаар явуулж ил тод, нээлттэй, үр өгөөжтэй болгоно.
- 4.5.Судалгааны үр дүнг орон нутгийн төрийн бодлого боловсруулахад ашиглана.
- 4.6.Болзошгүй гамшиг, эрсдэлээс хамгаалах санг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.7.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааг суманд шинээр бий болгоно.
- 4.8.Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.9.Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.10.Иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж тэдэнтэй хамтарч ажиллах.
- 4.11.Ханги Мандалын хилийн боомтыг түшиглэн "Ханги" багийг шинээр байгуулан төлөвлөлтийг зөв зохион байгуулалттайгаар хийж төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна.
- 4.12.Иргэдийн оролцоонд тулгуурласан Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлнэ.

ХАТАНБУЛАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 1-6/635
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Хөвсгөл сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөвсгөл сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл сумын сонгуулийн хороонд

Хавсралт.....⁸хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА



ОРОН НУТГИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, мөн Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, Дорноговь аймгийн Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, “Хөвсгөл сумаа хөгжүүлэх эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө 2024” болон ард иргэдээс гарсан санал хүсэлтэд тулгуурлан тооцоо судалгаанд үндэслэгдсэн, хүний хөгжил, аюулгүй байдлыг хангах зорилтыг агуулсан, төрөлх сумаа эрчимтэй хөгжүүлэх эрхэм зорилгыг дэвшүүлж сумын МАН-ын хорооноос мөрийн хөтөлбөрөө Сонгогч Танд толилуулж байна.

Сумын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, төсөв санхүүгийн зөв бодлогоор хангаж, их бүтээн байгуулалт өрнүүлэн, төрөлх нутгаа 2020-2024 он хүртэл эрчимтэй хөгжүүлэх цогц арга хэмжээг энэхүү мөрийн хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

/Тогтвортой орлоготой, ажлын байртай, оюунлаг, эрүүл иргэн Таны төлөө/

1.1 ЭРҮҮЛ МЭНД - АМЬДРАЛЫН БАТАЛГАА

1.1.1 Эрүүл мэндийн чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ.

1.1.2 Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулж эмнэлгийн үзлэг, үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй байлгах нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.3 Хүн амын дунд зохион явуулах эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулан үйл ажиллагааг нь сайжруулах

1.1.4 Сумын хүн эмнэлгийг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах ажлыг шийдвэрлэж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

1.1.5 Эмч, эмнэлгийн мэргэжлийн албан хаагчдын мэргэжил боловсролыг дээшлүүлж давтан сургалтанд хамруулна

1.1.6 Биеийн тамир спортын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ

1.1.7 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

1.1.8 Спортын төрлүүдийн сургалтыг чанаржуулан шилдэг тамирчдыг бэлтгэнэ.



1.1.9 Хүн амын дунд зонхилон тохиолддог өвчлөлийн шалтгааныг судлан тодорхойлж эрүүлжүүлэх зорилгоор “ЭРҮҮЛ ХӨВСГӨЛЧҮҮД” сумын дэд хөтөлбөрийг баталж хэрэгжүүлнэ

1.1.10 Эрүүл мэндийн төвийн автомашины парк шинэчлэл хийнэ.

1.2 БОЛОВСРОЛ- ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

1.2.1 Боловсролын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ

1.2.2 Хүүхдийн цэцэрлэг болон Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчныг улам сайжруулна.

1.2.3 Сургуулийн болон цэцэрлэгийн багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлж давтан сургалтанд хамруулна

1.2.4 Цэцэрлэгийн хүүхдийн анги бүлгүүдэд шаардагдах тоглоом, техник хэрэгслийг шийдвэрлэх.

1.2.5 Бүтэн болон хагас өнчин хүүхдийг боловсрол эзэмших, мэргэжил олгох нөхцлөөр дэмжинэ.

1.2.6 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэхэд анхаарч “Орон нутгийн сургуулийн шинэчлэл” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд онцгой анхаарч багшийн бүтээлч хандлагыг нэмэгдүүлж ажлын үр дүнгээрээ “ТЭРГҮҮЛЭГЧ” зорилтыг хангуулна.

1.2.7 Бүс, аймаг, улсын олимпиадад оролцож буй багш, сурагчдыг бодлогоор дэмжинэ. Тэргүүний сурагч, мэргэжлээрээ тэргүүлэгч багш нарыг урамшуулах бодлого баримтлана.

1.2.8 Багш нарын практикийг дээшлүүлэх бодлогын хүрээнд СӨБ, ЕБС-ийн багш нарын туршлага судлах ажилд дэмжлэг үзүүлнэ

1.2.9 Дотуур байрны сурагчдын ая тухтай амьдрах орчныг тохижуулж улам сайжруулна

1.2.10 Багш хөгжлийн төвийн орчныг сайжруулахад туслалцаа үзүүлнэ

1.2.11 “Боловсролыг дэмжих сан”-г өргөжүүлнэ

1.2.12 Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх номын сангийн үйл ажиллагааг өргөтгөж сурагчдын мэдлэг боловсролоо дээшлүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.2.13 Оюуны спортыг дэмжиж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сумын шатрын клубын үйл ажиллагааг дэмжинэ.

1.2.14 ЕБС-ийн 320 хүүхдийн багтаамжтай шинэ сургуулийн барилга барих ажлыг холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлэх.

1.2.15 Анги кабинет, лабораторийг тохижуулахад үе шаттай дэмжлэг үзүүлнэ.



1.2.16 Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг дэмжиж иргэд үйлчлэх орчин нөхцлийг бүрдүүлж, техник хэрэгслээр хангах

1.3 СОЁЛ УРЛАГ- ҮНЭТ БАЯЛАГ

1.3.1 Соёл урлагийн байгууллагын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, ажиллах нөхцлийг сайжруулж ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтанд хамруулна.

1.3.2 Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ

1.3.3 Номын сангийн номын фондыг нэмэгдүүлнэ

1.3.4 Сумын нутаг дэвсгэр дээрх түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамгаалалтанд нэмж авна.

1.3.5 Хөдөөгийн малчдад үзүүлэх урлаг соёлын арга хэмжээг тогтмолжуулан чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.3.6 Соёлын байгууллагын гэрэлтүүлэг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ.

1.3.7 “Соёл спортын цогцолбор төв” –ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.3.8 Улс, аймаг, сумын тусгай хамгаалалттай газруудыг хаягжуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарна.

1.4 АЖЛЫН БАЙР-ХӨДӨЛМӨРИЙН ҮР ШИМ

1.4.1 Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ.


1.4.2 Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлж, ажилгүйдлийг үе шаттайгаар бууруулах замаар иргэн бүр ажилтай, тогтвортой орлоготой байх, өрхийн дундаж орлогыг жил дараалан өсгөх бодлого барина.

1.4.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж ажлын байр бий болгож буй ажил олгогч, хувийн хэвшлийн жижиг дунд үйлдвэрлэл, хоршоолол, үйлчилгээ эрхлэгчдийг нэгдсэн бодлогоор дэмжиж, санхүүгийн чадавхтай болгох нөхцлийг бүрдүүлнэ.

1.4.4 Малжуулах төсөл хэрэгжүүлж иргэдийг малжуулах замаар ажилгүйдлийг бууруулж малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.4.5 Ажилгүй иргэдийг мэргэжил олгох төрөл бүрийн сургалтанд хамруулж ажлын байр бий болгох бодлого баримтална.

1.4.6 Өрхийн амжиргааны түвшинг шинэчлэн тогтоож нэн ядуу, ядуу өрхөд чиглэсэн нийгмийн халамжийн цогц арга хэмжээг төр засгийн бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлнэ.



1.5 ГЭР БҮЛ – ЗАЛУУЧУУД-ЭМЭГТЭЙЧҮҮД

1.5.1 Гэр бүлийг дэмжих чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч эрчимжүүлнэ.

1.5.2 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, залуу гэр бүл, ахмад настнуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймаг, суманд баригдах нийтийн орон сууцанд эхний ээлжинд хамруулах бодлого баримтална.

1.5.3 АА бүлгийн үйл ажиллагааг дэмжинэ

1.5.4 Мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулна.

1.5.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарал тавьж эрчимжүүлнэ.

1.5.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөл бүрийн төсөл хөтөлбөрт хамруулах бодлого баримтална.

1.6 АХМАДАА ДЭЭДЭЛЖ АЧЛАЛЫГ ХАРИУЛНА

1.6.1 Ахмадуудад чиглэсэн орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарал тавьж эрчимжүүлнэ.

1.6.2 Ахмад настнуудыг жилд 2-оос доошгүй удаа эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонд хамруулна.

1.6.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ахмадуудад хүргэх зорилгоор гэрт нь эмчилгээ сувилгаа хийдэг болгоно.

1.6.4 Сумын ахмадын байрыг улам тохижуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.6.5 Ахмадуудын хэрэгцээ чадамжид суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж орлогыг нь нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.



ХОЁР. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

Иргэдээ дээдэлсэн, Иргэдийнхээ итгэл дэмжлэгийг хүлээсэн

хариуцлагатай төрийн албыг бэхжүүлнэ

2.1 Бүх шатны төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулж хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлнэ

2.2 Төрийн байгууллагуудын төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг иргэд тогтмол авах боломжоор хангана

2.3 Төрийн албан хаагч ёс зүйг эрхэмлэж эрхэлсэн ажилдаа эзэн нь байж иргэдийн санал хүсэлтийг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэдэг байна.

2.4 Хөдөөгийн багуудын ажиллах нөхцлийг улам сайжруулж багийн албыг багийн иргэдэд ойр дөт ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

2.5 Аливаа төсөл, тендер шалгаруулалтыг ард иргэдэд ил тод, нээлттэй, үр өгөөжтэй, сумын иргэд өөрсдөө баг болж хэрэгжүүлдэг байх нөхцлийг нэмэгдүүлнэ.

2.6 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтанд тогтмол хамруулж байх

2.7 Орон нутагт нэн шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой анхаарч сурч боловсроход нь дэмжлэг үзүүлж эргэн сумандаа ирж ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

2.8 Төрийн албан хаагчдын компьютер, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилж ажиллах нөхцлийг сайжуулна

ГУРАВ. ХҮНС, ХАА-Н БОДЛОГО


3.1 “Эрүүл хүнс- Амьдралын баталгаа” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2 Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, “монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

3.3 ХАА-н чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг анхаарч эрчимжүүлнэ.

3.4 Мал сүргээ өсгөх малчдын санал санаачлагыг бүх талаар дэмжиж сүрэгт шилдэг омгийн малын эзлэх хувийн жинг тогтмол нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.5 Мал эмнэлэг үржлийн ажлын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх паразит өвчнийг устган малыг эрүүлжүүлэн нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлнэ.



3.6 “Ус-Чандмань эрдэнэ” хөтөлбөр боловсруулж малчдын ундны ус болон бэлчээрийн усан хангамжийг үе шаттайгаар нмэгдүүлж хувиараа худаг гаргасан иргэнийг бүх талаар дэмжиж урамшуулна.

3.7 Газар тариалан, хүлэмжийн аж ахуй эрхэлж төмс, хүнсний ногоо, нарийн ногоо, жимс жимсгэнэ тариалах иргэн, ААН-ийг бодлогоор дэмжинэ.

3.8 Тэмээчдын холбоог байгуулж тэмээн сүргийг өсгөх бодлогыг дэмжиж “Шилмэл хээлтүүлэгч-Торгон сүрэг” сумын хөтөлбөрийг баталж хэрэгжүүлнэ

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭГЧ - БАЯЛАГ БҮТЭЭГЧ

4.1 “Иргэн бүр санаачлагч - Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ

4.2 ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ.

4.3 “СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ийн зээл олголтонд тавих хяналтыг сайжруулж зөвхөн зориулалтын дагуу баялаг бүтээх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах иргэнд олгодог болгоно. Гэрээний үүргээ биелүүлээгүй, зориулалтын дагуу ашиглаагүй иргэн авсан зээлээ буцаан төлдөг бодлогыг эрчимжүүлнэ.

4.4 Сумын онцлогт тохирсон ЖДҮ хөгжүүлэх замаар “Ингэний сүүн бүтээгдэхүүн” нутгийн бренд бүтээгдэхүүн бий болгох санаачлагыг дэмжинэ.

4.5 Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, эрхлэх сонирхол бүхий иргэдийн гаргасан санал санаачлагын дагуу шаардлагатай сургалтуудыг орон нутагт зохион байгуулах, сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

4.6 Хүнсний ногоо тариалах ААН, иргэдийн санаачлагыг дэмжинэ

ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ- СУМАНДАА САЙХАН АМЬДАРЬЯ

5.1 Айл өрхүүдийг ээлж дараатайгаар хашаажуулах, сумын төвийн өнгө үзэмж, орчны ариун цэврийг сайжруулах бодлогыг нэмэгдүүлнэ.

5.2 Сумын төвд сайжруулсан автозам, явган хүний болон дугуйн зам барина,

5.3 Сумын төвийн гудамж талбайг ээлж дараатайгаар улам тохижуулна.

5.4 Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол бүхий төвлөрсөн орон сууц барих төр, хувийн санал санаачлагыг дэмжинэ.



5.5 Албан байгууллага, айл өрхүүдийг төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажлыг үргэлжлүүлнэ.

5.6 Сумын төвийн цахилгаан дамжуулах 04 шугамд засвар, шинэчлэл, өргөтгөл хийнэ

5.8 Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд мод тарих ажлыг эрчимжүүлнэ

5.9 “ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ”- ийг байгуулна

5.10 Иргэд, малчдыг орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ

5.11 ТАХ-ыг орон сууцжуулах бодлогыг үргэлжлүүлнэ.

5.12 ЭМТ-ийн автомашиныг шинэчлэнэ

5.13 Хүүхдийн зуслан, ахмадын сувиллын байр барьж хүүхдүүд амрах, ахмадууд сувилуулах нөхцлийг бүрдүүлнэ.

5.14 Хөдөөгийн багуудын тохижилтыг улам сайжруулж цахилгааны хангамжийг шинэлэг байдлаар шийдвэрлэн иргэд худалдаа, үйлчилгээ эрхлэх нөхцлөөр хангана. Мөн багийн төвүүдэд орчин үеийн шийдэл бүхий халуун усны асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.

5.15 Соёлын төвийн гадна фасадыг шинэчлэнэ.

5.16 Бэлчээрийг усжуулж баг бүрт инженерийн хийцтэй гүн өрмийн худаг нэмж гаргана.

5.17 Элст, Чулуут багт тавигдсан Unitel-ийн 2G сүлжээг холбогдох газарт уламжилж 4G сүлжээ болгоход бүхий л дэмжлэгийг үзүүлнэ

5.18 Ундны усны цэвэршүүлэх үйлдвэрт ус түгээх ухаалаг систем, тоног төхөөрөмж суурьлуулна

5.19 ЕБС-ийн 320 хүүхдийн шинэ сургуулийн барилга барих ажлыг холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлнэ.

5.20 Дэлгүүр, худалдаа, үйлчилгээний төвүүдийн гаднах талбайг тохижуулна

ЗУРГАА. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БОДЛОГО, НОГООН ОРЧИН

6.1 Байгаль орчны чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ.

6.2 Аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулна.

6.3 Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, нөхөрлөл, ААН, ТББ-уудын оролцоог дэмжинэ.



6.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн саналд үндэслэн шийддэг хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

6.5 Уул уурхайн тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллана.

6.6 Заган ойн хамгаалалтыг сайжруулна.

ДОЛОО. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АМГАЛАН ОРЧИН

7.1 Гэмт хэрэг, малын хулгай, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

7.2 Гамшгаас хамгаалах төрийн бодлого зорилтууд орон нутагт бүрэн хэрэгжих нөхцлийг бүрдүүлж үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

7.3 Нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

НАЙМ. ИТГЭЛТЭЙ ТҮНШЛЭЛ

8.1 Өөрийн болон жишиг сумдтай аймаг болон тэдгээрийн хөгжил, ажлын арга барил, туршлагатай танилцаж үр өгөөжийг сумын хөгжилд түлхүү ашиглах бодлого барьж ажиллана.

8.2 Сумынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх гадаад худалдааг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад анхаарна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 1-6/612
танай _____-ны № _____-т

**ЭРДЭНЭ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэ сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Эрдэнэ сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Эрдэнэ сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Эрдэнэ сумын сонгуулийн хороонд

Хавсралт. 6...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сумын Нийгэм, Эдийн Засгийн тогтвортой хөгжлийг хангаж, орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн хөгжлийг дэмжсэн, иргэдээ эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах, сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх зорилтыг агуулсан иргэдийн санал хүсэлт, эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэгдсэн мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Энэхүү мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр иргэд эрүүл, боловсролтой, ажилтай орлоготой болж, сум орон нутаг хөгжиж, өрхийн амьжиргааны түвшин дээшилнэ.

Улс, аймаг, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, төсөв, санхүүгийн зөв бодлогоор хангаж, төрөлх сумаа 2020-2024 он хүртэл хөгжүүлэх цогц арга хэмжээг авч хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

НЭГ. АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОДЛОГО

1.1 Ажлын байрыг нэмэгдүүлнэ

1.1.1 Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажил эрхлэлтийн түвшинг ахиулна.

1.1.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, уул уурхайг төрийн бодлогоор дэмжинэ.

1.1.3 Жижиг дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөл эрхэлж буй иргэд, хувийн хэвшлийнхэнийг нэгдсэн бодлогоор дэмжинэ.

1.1.4 “Малжуулах төсөл” хэрэгжүүлж, иргэдийг малжуулах замаар ажилгүйдлийг бууруулж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.1.5 Ажилгүй иргэдийг давтан сургаж, ажлын байраар хангах бодлого баримтална.

1.1.6 Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, уул уурхай, ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагууд нь эхний ээлжинд бүртгэлтэй ажил хайгч иргэдийг ажлын байраар хангах бодлого барина.

1.1.7 Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлж нэн ядуу, ядуу өрхөд чиглэсэн нийгмийн халамжийн цогц арга хэмжээг төр, засгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1.2 Ахмад, залуу үе, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих бодлого.

1.2.1 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтална.

1.2.2 Ахмад настнуудыг жилд нэг удаа эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг оношилогоонд хамруулна.



- 1.2.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ахмадуудад хүргэх зорилгоор гэрт нь эмчилгээ сувилгаа хийдэг бодлого баримтална.
- 1.2.4 Мэргэжилтэн ахмадуудаас бүрдсэн зөвлөгөө өгөх ахмадын зөвлөлийг байгуулна.
- 1.2.5 Ахмадуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймагт баригдах нийтийн орон сууцанд эхний ээлжинд хамруулах бодлого баримтална.
- 1.2.6 Хүүхэд хамгааллын асуудлыг нэн тэргүүнд тавьж эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, хүүхдийн хүчирхийллийн эсрэг холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 1.2.7 “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилтийг хангах талаар залуучуудын санал санаачлагыг дэмжиж ажиллана.
- 1.2.8 Залуу үеийг хорт зуршил болох архи, тамхины хэрэглээг багасгах, АА бүлгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.2.9 Залуу гэр бүлийг бодлогоор дэмжинэ.
- 1.2.10 Иргэд удам судраа дээдэлж, өрх бүр ургийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлж, Монгол хэл, уламжлалт ёс, зан заншлаа дээдлэх, үр хүүхдэдээ өвлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 1.2.11 Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалтай гэр бүлийн тоог нэмэгдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 1.2.12 Гэр бүлийг дэмжих чиглэлээр улс, орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.2.13 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Залуу гэр бүлийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймагт баригдах нийтийн орон сууцанд хамруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.2.14 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарал тавьж, эрчимжүүлнэ.

1.3 Эрүүл мэнд-Амьдралын баталгаа

- 1.3.1 Эрүүл мэндийн чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.
- 1.3.2 ЭМТ-ийг их эмчээр бүрэн хангаж тогтвор суурьшилтай ажиллуулж байр орон сууцаар хангана. “Бүрдэнэбулаг” бөөрний сувиллын үйл ажиллагааг эрчимжүүлж өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлж үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 1.3.3 Эрүүл мэндийн төвийг стандартад заагдсан эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.3.4 ЭМТ-ийн хуучин барилга ажилчдын орон сууц болгож, ажилчдын нийгмийн асуудлыг дэмжинэ.
- 1.3.5 Бүх насны иргэдийг хамарсан “Хөдөлгөөн-эрүүл мэнд” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Хоёр жилд нэг удаа спортын бүх төрлөөр “спортын наадам” зохион байгуулна.

1.4 Боловсрол, мэдлэг-Хөгжлийн түлхүүр



- 1.4.1 Боловсролын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.
- 1.4.2 Оюутан, залуучуудыг гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид орон нутагт нэн шаардлагатай нарийн мэргэжлээр суралцагчидыг бодлогоор дэмжин, сумандаа ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.4.3 Хагас болон бүтэн өнчин хүүхдийг боловсрол эзэмших, мэргэжил олгоход бодлогоор дэмжинэ.
- 1.4.4 Суурь боловсролд онцгой анхаарч, анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлж, шинэ дотуур байрны зарим өрөө тасалгааг дугуйлан, секцийн зориулалтаар ашиглуулна.
- 1.4.5 Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчныг сайжруулж, техник хөдөлмөрийн танхимтай / кабинетууд байгуулах/ болгож тоног төхөөрөмжөөр хангах
- 1.4.6 Гэр цэцэрлэг, хүүхэд асрах төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.
- 1.4.7 Үдийн цай хөтөлбөрийн чанарыг шинэ түвшинд хүргэж, худалдан авах үйл ажиллагаа, тендерийг ил тод оновчтой зохион байгуулна.
- 1.4.8 Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх номын сангийн үйл ажиллагааг өргөтгөж, сурагчдын мэдлэг боловсролоо дээшлүүлэх орчинг бүрдүүлнэ.
- 1.4.9 Ерөнхий боловсролын сургуулийн болон цэцэрлэгийн багш нарын мэргэжил, боловсролыг дээшлүүлж, давтан сургалтад хамруулна.
- 1.4.10 ЕБС, цэцэрлэгийг эмчтэй болгоно.
- 1.4.11 ЕБС-ийн сэтгэл зүйчтэй болгоно.
- 1.4.12 Төмөр замын хүүхдийн цэцэрлэгийн нөөц бололцоог ашиглан анги, бүлэг шинээр нээх боломжийг судална.

1.5 Соёл урлаг-Үнэт баялаг

Соёлын өвийг хамгаалж, оюуны бүтээл, авъяасыг дэмжинэ.

- 1.5.1 Соёлын биет болоод биет бус өвийг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.5.2 Соёл урлагийн байгууллагуудын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, ажиллах нөхцлийг сайжруулж, ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.
- 1.5.3 Соёлын төвийн шаардлагатай зарим техник төхөөрөмжийг шинэчилнэ.
- 1.5.4 Хүүхэд багачуудын авъясыг бодлогоор дэмжиж сум орон нутгийн ард иргэдийн авъяас билгийг тодруулж, дэмжих зорилгоор 2 жилд 1 удаа урлагийн наадмыг зохион байгуулна.

ХОЁР. ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1.1. Сумын хөгжлийн 2021-2031 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.
- 2.1.2. Эрүүл мэндийн төв шинээр барина.
- 2.1.2 Соёл спортын цогцолбор шинээр барина.
- 2.1.3 “Ахмадын өргөө” барьж ашиглалтанд оруулна.
- 2.1.4 Бүрдэнэ бөөрний сувилалыг хатуу хучилттай замаар босоо тэнхлэгийн авто замтай холбоно.
- 2.1.5 Өргөн сумаас 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдоно.



- 2.1.5 Сумын төвд сайжруулсан зам тавина.
- 2.1.6 Тэгш гудамж төсөл хэрэгжүүлнэ.
- 2.1.7 Бэлчээрийн усан хангамжийг сайжруулан жилд гүн өрмийн худаг шинээр гаргана.
- 2.1.8 Зарим багуудад малын вакцины хашаа, Угаалгын ванн барина.
- 2.1.9 Сумын төвийн гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэнэ.
- 2.1.10 Багийн төвүүдэд их засвар хийнэ.
- 2.1.11 Хилийн торон саадыг засварлана.
- 2.1.12 Сумын төвийн албан байгууллага, ААН-ийг камержуулана.
- 2.1.13 Сумын төвийн усан сангийн ариун цэврийн бүсийг харуул хамгаалалттай болгож, гадна талыг хашаажуулна.
- 2.1.14 Хүн амын ундны усан хангамжийг сайжруулж, бүх ус түгээх цэгт ухаалаг систем нэвтрүүлж, ус цэнгэгшүүлэх төхөөрөмж суурилуулна.
- 2.1.15 Нэгдсэн шугам сүлжээнд ААН нэгж, айл өрхийг иргэдийн оролцоотой ээлж дараатай холбуулна.
- 2.1.16 Алслагдсан айл өрхүүдэд үнэн холбооны сүлжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.17 "Эко бие засах байгууламж" барина.
- 2.1.18 Төмөр замын зарим хэсэг, зөрлөгүүдэд биеийн тамирын талбай байгуулна.
- 2.1.19 Төмөр замын хүүхдийн цэцэрлэгийн гадна талбайг тохижуулна.
- 2.1.20 18-ын худагт сум дундын агропарк байгуулна.

2.2. Хүнс, хөдөө аж ахуй- Иргэн бүрийн хэрэгцээ

- 2.2.1 "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", хөдөө аж ахуйн чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.
- 2.2.2 Мал сүргээ өсгөх малчдын санал санаачлагыг бүх талаар дэмжиж, мал сүрэгт нутгийн шилдэг омгийн болон нутгийн сайжруулсан үүлдэрийн малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 2.2.3 Удам дамжсан малчин, малчдын залуу халааг бэлтгэж, сурч хөдөлмөрлөх нөхцөл боломжоор хангана.
- 2.2.4 Малчдыг малын индексжүүлсэн даатгалд хамруулах замаар байгалийн гамшгаас үүдсэн эрсдлийн хохирлыг багасгана.
- 2.2.5 "Ус-Чандмань эрдэнэ" хөтөлбөр боловсруулж, малчдын ундны ус болон бэлчээрийн усан хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлж, хувиараа худаг гаргасан иргэнийг бүх талаар дэмжинэ.
- 2.2.6 "18-ын тариалан" төсөл хэрэгжүүлтийг эрчимжүүлж, салхины хамгаалалт хийх ажлыг судална.
- 2.2.7 Хүлэмжийн аж ахуй эрхэлж нарийн ногоо, жимс жимсгэнэ тариалж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

2.5 Үйлдвэрлэгч-Баялаг бүтээгч

- 2.5.1 "Иргэн бүр санаачилагч-Өрх бүр үйлдвэрлэгч" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.5.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.



2.5.3 Босоо тэнхлэгийн авто зам дагуу авто засвар, худалдаа, үйлчилгээний төвүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах санаачилгыг дэмжинэ.

2.5.4 Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон бусад үйлдвэр, байгууллагыг түшиглэн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЭКОЛОГИЙН БОДЛОГО

/Байгальд ээлтэй хөгжил, иргэндээ таатай орчны төлөө хамтдаа/

- 3.1 Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй дэд төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.
- 3.2 Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох ардын уламжлалт арга ухаанд тулгуурласан сургалтуудыг үе шаттай зохион байгуулна.
- 3.3 Улсын болон аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, ховор ан амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулна.
- 3.4 Тухайн орон нутгийн хэмжээнд ховордсон ан амьтан, ургамлыг дахин нутагшуулах санал санаачилга гаргасан Олон Улсын болон олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 3.5 Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжинэ.
- 3.6 Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, бохирдон доройтож, орхигдсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудаар хийлгэнэ.
- 3.7 Сумын хэмжээнд мод тарих бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 3.8 Аялал жуулчлалын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч, эрчимжүүлнэ.
- 3.9 Сумын онцлогт тохирсон аялал жуулчлалын маршрут бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.10 Сумын төвийн гадаад орчны ариун цэвэр тохижилтын ажлыг сайжруулна.

ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

4.1 Иргэдийн оролцоон-нээлттэй төрийн алба

- 4.1.1 Төрийн захиргааны байгууллагын ажлыг хуульд нийцүүлэн, шууд тасралтгүй, хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагааг нь тод нээлттэй, үр нөлөөтэй, бусдын эх ашиг сонирхол хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд, тэдгээрт урьдчилан мэдэгдэж, оролцоог хангахад ажлаа чиглүүлнэ.
- 4.1.2 Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг сайжруулж, түргэн шуурхай, чирэгдэлгүй, иргэдийн оролцоотой хүргэх "Цахим төрийн алба" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 4.1.3 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл хүсэлтийг шуурхай шийдэж, биелэлтийг цахимаар хянадаг болно.
- 4.1.4 Төрийн албан хаагч ёс зүйг эрхэмлэн сахиулж, тэдний мэдлэг чадвар эерэг хандлагыг төлөвшүүлж, эрхэлсэн ажилдаа эзэн нь байх бодлого баримтална.
- 4.1.5 Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлнэ.
- 4.1.6 Аливаа төсөл, тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй, үр өгөөжтэй болгоно.
- 4.1.7 Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож, ажлын арга барил, үр өгөөж, иргэд олон нийтийг дагуулж, манлайлах чадварыг нэмэгдүүлнэ.
- 4.1.8 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, зарим төрийн албан хаагчдыг орон сууцаар хангана.
- 4.1.9 Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тэдэнтэй хамтарч ажиллана.

4.2 Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин

- 4.2.1 Гэмт хэрэг, малын хулгай, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.2.2 Нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.3 Архидалт, хүчирхийллээс гэр бүлийг хамгаалах төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.
- 4.2.4 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.
- 4.2.5 Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах төрийн бодлого, зорилтууд орон нутагт бүрэн хэрэгжих нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Монгол Ардын Намын хорооноос дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр нь нийгмийн ардчиллын үзэл баримтлалын хүрээнд нарийн тооцоо судалгаанд тулгуурласан ба иргэн төвтэй Эрдэнэ сумыг хөгжүүлэхэд чиглэгдэж, ард иргэдийн амьдралд бодит ахиц гаргах баримт бичиг юм.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН

МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 16/339
танай _____-ны № _____-т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Замын-Үүд сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Замын-Үүд сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Замын-Үүд сумын сонгуулийн хороонд

Хавсралт...8...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Замын-Үүд сумын Монгол Ардын
Намын хорооны 2020.06.08-ны
өдрийн 13-р хуралдаанаар батлав



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох
Замын-үүд сумын Монгол Ардын Намын хорооны
“Бид хамтдаа-Хүчээ нэгтгээ” мөрийн хөтөлбөр

Уриа: Сонголтыг бататгаж
Илүү ихийг бүтээнэ.

Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлого 2050 хөтөлбөр, Монгол Ардын намаас Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлэн оролцсон мөрийн хөтөлбөрийг үндэс болгосон Замын-Үүд нутгаа илүү эрчимтэй хөгжүүлэх, иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан тооцоо судалгаанд үндэслэгдсэн, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдал, боловсрол, соёлын хэрэгцээг хангах “Бид хамтдаа-Хүчээ нэгтгээ” мөрийн хөтөлбөрийг Замын-Үүд сумын Монгол ардын намын хорооноос эрхэм сонгогч танд өргөн барьж байна.

Нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжлийн ололт амжилтыг бататган, тогтвортой, үр ашигтай өсөлтийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, төсөв санхүүгийн ухаалаг бодлогоор зангидан эх орны алтан босго Замын-Үүд нутгаа 2020-2024 онд илүү хурдацтай хөгжүүлэх арга хэмжээг бид хамтдаа багаараа энэхүү дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрөөрөө хэрэгжүүлнэ. Та бүхэн дэмжээрэй бид улам хичээх болно.

Нэг. Нийгмийн бодлогын зорилт та бүхэндээ

1.1 Эрүүл мэнд – Амьдралын эх сурвалж

1.1.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг үе шаттайгаар ахиулан эрүүл мэндээ хамгаалах урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг шат ахиулна.

1.1.2 Халдварт өвчин томуугийн дэгдэлтийг бууруулах сумын бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгоно.

1.1.3 Гэр хорооллын эрүүл ахуй, халдвар хамгааллын оновчтой хувилбарыг сонгон, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах.

1.1.4 Эмч, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах.

1.1.5 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээг чанаржуулан, нөхөн сэргээх уламжлалтын тасаг байгуулах.

1.1.6 Бөөрний дутагдлын тоног төхөөрөмжийг эмчилгээнд ашиглах

1.1.7 Хүүхдийн эрүүл мэнд, эрүүл шүд хөтөлбөрийг үргэлжлүүлэх



1.2 Боловсрол, соёл урлаг – Бидний хэрэгцээ

1.2.1 Үндэсний бахархал эв нэгдлээ дээдэлж, эх орноороо бахархдаг хүүхэд залуусыг төлөвшүүлнэ.

1.2.2 Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үр өгөөжийг дээшлүүлж, тэдний бие даах чадвар, суурь хүмүүжилд ахиц гаргана.

1.2.3 Сурагчдыг хорт зуршилаас ангид суралцахыг эрхэм зорилго болгосон орчинг ерөнхий боловсролын сургуулиудад тэргүүлэх чиглэл болгоно.

1.2.4 Багш нарын ур чадвар, техник хэрэгслийн хангамжийг улам сайжруулах.

1.2.5 Залуучуудын насан туршийн боловсролын хэрэгцээнд тохирсон хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.

1.2.6 Мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, орон нутгийн сургалтыг оновчтой болгон хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлнэ.

1.2.7 Түүх соёлын өвийг хамгаалах, сэргээх, уламжлан хөгжүүлэх, орон нутгийн музей байгуулна.

1.2.8 Мэдээллийн технологид суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлнэ.

1.3 Иргэдийн нийгмийн оролцоо чадавхи, чадамж – Бидний зүтгэл

1.3.1 Төлөөллийн ардчилалыг бэхжүүлж, иргэдийн санал санаачлагад тулгуурлан, тулгамдсан асуудлыг судалгаа дүгнэлт, төсөл хөтөлбөр гарган шийдвэрлэх.

1.3.2 Багийн иргэдийн нийтийн хурлын чадамж, чадавхийг дээшлүүлэх, эрх хэмжээг өргөтгөх.

1.3.3 Иргэдийн оюун санааны хөгжлийн түвшинг хурдацтай ахиулах, түүний үр өгөөжийг эдийн засгийн эргэлтэнд оруулах.

1.3.4 Төрийн болон үйлчилгээний байгууллагаас иргэдэд мэдээлэл шуурхай хүргэн санал хүсэлт авах, сонсох, цахим холбоог боловсронгуй болгох.

1.3.5 Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх, залуу гэр бүлийг орон сууцтай болоход нь дэмжиж хамтран ажиллана.

1.3.6 Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийг байгуулах.

1.3.7 Улс хооронд зорчигч тээвэр эрхлэгчдийг дэмжиж үйлчилгээний соёл стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.

Хоёр: Эдийн засгийн бодлого – Эх нутгийн хөгжил

2.1 Аж үйлдвэр - Хөгжлийн тулгуур

2.1.1 Нефть боловсруулах үйлдвэр, төмөр замын бүтээн байгуулалтад оролцох мэргэжлийн ажилчид, хүний нөөцийг бүрдүүлэхэд идэвхи санаачлагатай оролцох.

2.1.2 Эдийн засгийн чөлөөт бүс, Цагаан суваргын үйлдвэрт ажиллах аж ахуй нэгж иргэдийн оролцоог бодлогоор дэмжинэ.

2.1.3 Нүүрс, зэс, төмрийн хүдрийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах, тээвэрлэх ажиллаганд хүний нөөцөө зохистой хувиарлан оролцох.



2.1.4 Мал эрүүлжүүлэх, нядлах, арьс шир, ноос боловсруулах дунд үйлдвэр байгуулж ашиглах.

2.1.5 Төмөр замын логистикийн чадлыг бүрэн эзэмших

2.1.6 “Их говийн зоригтнууд” аж үйлдвэрийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

2.1.7 Экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төслийг эхний ээлжинд дэмжиж бүтээгдэхүүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.

Хилийн боомтын алба хаагчид, иргэдийн шинэ сууршилын бүс бий болгох.

2.1.8 Хуванцар, аккумуляторын үйлдвэр байгуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.2 Хот байгуулалт – Тохилог орчин

2.2.1 Таван одтой зочид буудал барина.

2.2.2 Замын-Үүдийн дулаан, цэвэр, бохир усны дэд бүтцийг ашиглалтад оруулах.

2.2.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хамтарсан аялал жуучлалын бүс байгуулах.

2.2.4 Гэр хорооллын дулаан, цэвэр, бохир усны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

2.2.5 Эрдэмтэд судлаачдын баг зөвлөлийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих үр өгөөж, бүтээмжийг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах.

2.2.6 Нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулна.

2.2.7 Банк санхүүгийн байгууллагын мөнгө хүүлэлийг бууруулах иргэдийн санал хүсэлтийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

2.2.8 Сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 48 га газрыг дахин төлөвлөлтөд оруулж

2.2.9 Орон сууцнуудын үйлчилгээг хариуцсан орон сууц нийтийн аж ахуйн газрыг байгуулна.

2.2.10 Даралттай 1000м3 усан сан барих

Гурав: Байгаль орчин, Аялал жуулчлал хөдөө аж ахуйн бодлого – Сайхан амьдарцгаая

3.1 Байгалийн доройтол, нөхөн сэргээлт, ногоон хөгжлийн хөтөлбөр, бодлого зорилтод зориулах хөрөнгө санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх.

3.2 Ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх.

3.3 Сэргээгдэх эрчим хүчний байгууламжийн ашиглалтыг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх.

3.4 Хүлэмжийн аж ахуйг урамшуулан дэмжиж, нарийн ногооны хангамжид ахиц гаргах.

3.5 18-н худгийг түшиглэн сум дундын агро парк байгуулах боломжийг судлан, ашиглах.

3.6 Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг урамшуулан, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.

3.7 Хөдөө аж ахуйн боловсруулах дунд үйлдвэрлэлийг олшруулах. /арьс шир элдэх, ноос ноолуур угаах/

3.8 Аялал жуулчлалын байнгын ажиллагаатай бааз байгуулах.

3.9 Дээрх салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт сумын эдийн засгийн 40%-г бүрдүүлнэ.



- 3.10 Явган зам, дугуйн замыг нэмэгдүүлэх, гэр хороололд нийтийн биеийн тамирын талбай байгуулах.
- 3.11 Авто замын хилийн боомтын үйл ажиллагааг 3-4 цагаар сунгах боломжийг судална.
- 3.12 Цахилгаан шугам сүлжээний иж бүрэн шинэчлэлтийг хийх.
- 3.13 Сайжруулсан шахмал болон хийн түлшний хэрэглээг өргөжүүлнэ.
- 3.14 Хог хаягдлыг дахин боловсруулах, ангилан ялгах ажлыг ээрчимжүүлж "Цэвэр хот" төслийг хэрэгжүүлнэ.
- 3.15 Хог хаягдлын цэгийг 2-р зэрэглэлийн шаардлагад хүргэж, менежментийг сайжруулна.
- 3.16 Боловсон бие засах газар, био бие засах газрын ашиглалтыг нэмэгдүүлэх.
- 3.17 Саарал ус боловсруулах технологи нэвтрүүлэх, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.
- 3.18 "Эко 00" төсөл хэрэгжүүлэх.
- 3.19 "Утаагүй Замын-Үүд" хөтөлбөр хэрэгжүүлэх.
- 3.20 Аялал жуулчлалын "Борхойн тал" төв байгуулах.

**Дөрөв: Төрийн ажил, үйлчилгээний
бодлого – Хариуцлагатай ёс зүйтэй төр**

- 4.1 Төрийн алба, үйлчилгээнд чадавхийг үндэслэсэн ёс зүй, хууль дээдлэх зарчим, шударга ёсыг хатуу баримтлах.
- 4.2 Төсөл, хөтөлбөр, гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээг өргөтгөх, чанаржуулах.
- 4.3 Хил хооронд үйлчлэх жижиг тэрэгний үйлчилгээний соёл стандарт чанарыг сайжруулах.
- 4.4 Боомтын үйл ажиллагаа, хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлнэ.
- 4.5 Авлигын асуудлыг шийдвэрлэхэд нутгийн захиргааны байгууллагын оролцоог идэвхижүүлж, татвар төлөгчдийг хохиролгүй болгоход ахиц гаргана.
- 4.6 Сумын бүх салбарын хөтөлбөр, төсөл, чиглэл, бодлогын хэрэгжилтийн үр өгөөжид дүн шинжилгээ хийж, бодлого зорилтыг уялдуулан, давхардал хийдэгдлийг арилган, үр дүнг дээшлүүлэх.
- 4.7 Хууль сахиулах, хил хамгаалах, хилийн хяналтын байгууллагуудын төрийн үйлчилгээг цахимжуулах, бүртгэл хяналтын техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал, хангамжийг сайжруулах.
- 4.8 Мөнхийн 2 хөрш болон 3 дахь хөрштэй гадаад харилцааг өргөтгөх, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргана.
- 4.9 Чадавхийн зарчимд суурилсан төрийн албан тушаалын шатлал ахих нөхцлийг бүрдүүлж, бүх төрийн албан хаагчийн урамшууллыг ажил үүргийн үр дүнтэй уялдуулна.
- 4.10 Хүний эрхийн баталгааг хангах, авилга албан тушаалын гэмт хэргээс сэргийлж, хүчирхийлэл мансуурлын эсрэг бүх нийтийн боловсролыг чанаржуулах, зөв амьдралын дадал хэвшилд залуучуудыг сургана.
- 4.11 Төрийн явуулын үйлчилгээний хүрээ, давтамж, чанар өгөөжийг дээшлүүлнэ.



Тав: Багийн хөгжил – Бидний амьдрал

5.1 Нэгдүгээр багийн зорилт:

1. Дулаан цахилгааны станцыг ашиглалтанд оруулж, хэрэглэгчдийг дулааны тогтвортой эх үүсвэр, хэрэглээний халуун усаар хангана.
2. Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх.
3. Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулах.
4. 1-р багийн төрийн үйлчилгээний төв барих.
5. Цахим орчны мэдээллийн төв, номын сан байгуулах.
6. Ундны усны цэвэршүүлэх гэрийн төхөөрөмж ашиглах.
7. Цэцэрлэгт талбай байгуулах /хаан банкны ойролцоо/

5.2 Хоёр дугаар багийн зорилт:

1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний төв барих.
2. Хөл бөмбөгийн талбай бүхий спорт талбай байгуулах.
3. Гэр хорооллын газар зохион байгуулалт “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлэх.
4. Гэр хороололд авто зам барих.
5. Саарал ус ашиглах технологи нэвтрүүлэх.
6. Хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, авто зогсоол нэмэгдүүлэх.
7. Камержуулалтыг сайжруулах.
8. Гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.
9. “Утаагүй Замын-Үүд” хөтөлбөр хэрэгжүүлэх.
10. Хашаандаа тохилог орон сууц барьж 10 хувьд ногоон байгууламж байгуулсан иргэдийг ипотекийн зээлд хамруулах.
11. Том машины нэгдсэн зогсоол барина.

5.3 Гурав дугаар багийн зорилт:

1. Хөрс, газрыг салхины элэгдлээс хамгаалах “Борхойн Баянбүрд” төсөл хэрэгжүүлэх.
2. Чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх цэцэрлэгт био хүрээлэн хүүхдийн парк барих.
3. Гэр хорооллын газар зохион байгуулалт “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлэх.
4. Гэр хороололд авто зам барих.
5. Хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, авто зогсоол нэмэгдүүлэх.
6. Камержуулалтыг сайжруулах.
7. Гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.
8. 960 хүүхдийн сургууль ашиглалтанд оруулна.
9. “Мал эрүүлжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрчимжүүлэх.
10. Автобус, нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх.
11. Бэлчээрийн менежмент төсөл хэрэгжүүлэх.
12. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх.



13. Мал аж ахуйн фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.

5.4 Сүлд багийн зорилт:

1. Багийн төрийн үйлчилгээний төв барих.
2. 34. Үе шаттайгаар дахин төлөвлөлт хийх.
3. Ундны усны гэрийн цэвэршүүлэх төхөөрөмж ашиглах.
4. “Утаагүй Замын-Үүд” хөтөлбөр хэрэгжүүлэх.
5. Амины тохилог орон сууц барих иргэдийг ипотекийн зээлд хамруулах.
6. 4D кино театр барьж байгуулах.
7. Камержууллалтыг сайжруулах.
8. Хувийн орон сууцны дэд бүтцийг төв шугам сүлжээнд холбоно.
9. Бага сургуулийн спорт заал барина.

5.5 Борхойн багийн зорилт:

1. Хүнсний ногооны механикжсан агуулах байгуулна.
2. Гэр хорооллын газар зохион байгуулалт “Тэгш гудамж” төсөл хэрэгжүүлэх.
3. Гэр хороололд авто зам барих.
4. Хүүхэд залуучуудын хөгжлийн төв барих.
5. Хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, авто зогсоол нэмэгдүүлэх.
6. Камержуулалтыг сайжруулах.
7. Гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.
8. “Борхойн наран” өрхийн эмнэлэг байгуулах.
9. “Утаагүй Замын-Үүд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
10. Хөрс, газрыг салхины элэгдлээс хамгаалах “Борхойн Баянбүрд” төсөл хэрэгжүүлнэ.
11. Хашаандаа тохилог орон сууц барьж 10 хувьд ногоон байгууламж байгуулсан иргэдийг ипотекийн зээлд хамруулах.
12. Худалдаа үйлчилгээний мега төв байгуулахыг дэмжинэ.
13. Явган болон дугуйн зам байгуулна. /төв зам дагуу/
